Oracle-г суулгах зааварт тайлбарласнаар хуваалцсан санах ойн хамгийн их хэмжээг тохируулах хэрэгтэй. FreeBSD дээр `SHMMAX`-г битгий ашиглаарай. `SHMMAX` нь ердөө л `SHMMAXPGS` болон `PGSIZE`-с тооцоологдон гаргагддаг. Тийм болохоор `SHMMAXPGS`-г тодорхойл. Бусад бүх тохируулгууд зааварт тайлбарласны дагуу ашиглагдаж болно. Жишээ нь:

```
options SHMMAXPGS=10000
options SHMMNI=100
options SHMSEG=10
options SEMMNS=200
options SEMMNI=70
options SEMMSL=61
```

Эдгээр тохируулгуудыг өөрийн **Oracle**-ийн хэрэглээнд тааруулж тохируулах хэрэгтэй.

Мөн цөмийн тохиргооны файлдаа дараах тохируулгуудтай байгаа эсэхээ бас шалгаарай:

```
options SYSVSHM #SysV shared memory
options SYSVSEM #SysV semaphores
options SYSVMSG #SysV interprocess communication
```

10.6.3.2 Oracle бүртгэл

Өөр бусад бүртгэл үүсгэдэг шигээ `oracle` бүртгэл үүсгэнэ. `oracle` бүртгэл нь Линуксийн бүрхүүл өгөх шаардлагатай цорын ганц тусгай бүртгэл юм. `/etc/shells` файлд `/compat/linux/bin/bash`-г нэмээд `oracle` хэрэглэгчийн бүрхүүлийг `/compat/linux/bin/bash` гэж тохируулна.

10.6.3.3 Орчин

`ORACLE_HOME` болон `ORACLE_SID` зэрэг ердийн **Oracle** хувьсагчуудаас гадна та дараах орчны хувьсагчуудыг тохируулах ёстой:

Хувьсагч	Утга
`LD_LIBRARY_PATH`	`$ORACLE_HOME/lib`
`CLASSPATH`	`$ORACLE_HOME/jdbc/lib/classes111.zip`
`PATH`	`/compat/linux/bin /compat/linux/sbin /compat/linux/usr/bin /compat/linux/usr/sbin /bin /sbin /usr/bin /usr/sbin /usr/local/bin $ORACLE_HOME/bin`

Бүх орчны хувьсагчуудыг `.profile`-д тохируулахыг зөвлөдөг. Гүйцэд жишээ бол дараах байна:

```
ORACLE_BASE=/oracle; export ORACLE_BASE
ORACLE_HOME=/oracle; export ORACLE_HOME
LD_LIBRARY_PATH=$ORACLE_HOME/lib
export LD_LIBRARY_PATH
ORACLE_SID=ORCL; export ORACLE_SID
ORACLE_TERM=386x; export ORACLE_TERM
CLASSPATH=$ORACLE_HOME/jdbc/lib/classes111.zip
export CLASSPATH
```

```
PATH=/compat/linux/bin:/compat/linux/sbin:/compat/linux/usr/bin
PATH=$PATH:/compat/linux/usr/sbin:/bin:/sbin:/usr/bin:/usr/sbin
PATH=$PATH:/usr/local/bin:$ORACLE_HOME/bin
export PATH
```

10.6.4 Oracle-ийг суулгах

Линуксийн эмуляторын хайхрамжгүй бүрэн бүтэн бус байдлаас болоод суулгагчийг эхлүүлэхээсээ өмнө та `.oracle` санг `/var/tmp` дотор үүсгэх хэрэгтэй болдог. Үүнийг `oracle` хэрэглэгч эзэмшихээр болгох хэрэгтэй. Та **Oracle**-г ямар ч асуудалгүйгээр суулгаж чадах ёстой. Хэрэв танд асуудлууд учирвал эхлээд өөрийн **Oracle** тархац ба/эсвэл тохиргоог шалгах хэрэгтэй! **Oracle**-г суулгасныхаа дараа та дараах хоёр дэд хэсэгт тайлбарласан нөхөөсүүдийг хийж өгөх хэрэгтэй.

Байнга учирдаг асуудал бол TCP протоколын хувиргагч зөв суулгагдаагүй байдаг явдал юм. Үүнээс болоод та ямар ч TCP сонсогч эхлүүлж чадахгүй. Дараах үйлдлүүд нь энэ асуудлыг шийдэхэд тусалдаг:

```
# cd $ORACLE_HOME/network/lib
# make -f ins_network.mk ntcontab.o
# cd $ORACLE_HOME/lib
# ar r libnetwork.a ntcontab.o
# cd $ORACLE_HOME/network/lib
# make -f ins_network.mk install
```

`root.sh`-г дахин ажиллуулахаа битгий мартаарай!

10.6.4.1 root.sh-д нөхөөс хийх

Oracle-г суулгаж байхад `root` эрхээр хийгдэх шаардлагатай зарим үйлдлүүд `root.sh` гэж нэрлэгдсэн бүрхүүлийн скриптэд бичигдсэн байдаг. Энэ скрипт нь `orainst` санд бичигдсэн байдаг. `chown` тушаалын зөв байрлалыг ашиглахаар болгож дараах нөхөөсийг `root.sh`-д хийх хэрэгтэй, эсвэл өөрөөр скриптийг Линуксийн эх бүрхүүл дээр ажиллуулах хэрэгтэй.

```
*** orainst/root.sh.orig Tue Oct 6 21:57:33 1998
--- orainst/root.sh Mon Dec 28 15:58:53 1998
***************
*** 31,37 ****
# This is the default value for CHOWN
# It will redefined later in this script for those ports
# which have it conditionally defined in ss_install.h
! CHOWN=/bin/chown
#
# Define variables to be used in this script
--- 31,37 ----
# This is the default value for CHOWN
# It will redefined later in this script for those ports
# which have it conditionally defined in ss_install.h
! CHOWN=/usr/sbin/chown
#
# Define variables to be used in this script
```

CD-ээс **Oracle**-г та суулгахгүй үед `root.sh`-д зориулсан эхийг нөхөж болно. Үүнийг `rthd.sh` гэдэг бөгөөд эх модны `orainst` санд байрладаг.

10.6.4.2 genclntsh-д нөхөөс хийх

`genclntsh` скрипт нь хуваалцсан ганц клиентийн санг үүсгэхэд ашиглагддаг. Үзүүлбэрүүдийг бүтээж байхад үүнийг ашигладаг. `PATH`-н тодорхойлолтыг тайлбар болгохын тулд дараах нөхөөсийг хийх хэрэгтэй:

```
*** bin/genclntsh.orig Wed Sep 30 07:37:19 1998
--- bin/genclntsh Tue Dec 22 15:36:49 1998
***************
*** 32,38 ****
#
# Explicit path to ensure that we're using the correct commands
#PATH=/usr/bin:/usr/ccs/bin export PATH
! PATH=/usr/local/bin:/bin:/usr/bin:/usr/X11R6/bin export PATH
#
# each product MUST provide a $PRODUCT/admin/shrept.lst
--- 32,38 ----
#
# Explicit path to ensure that we're using the correct commands
#PATH=/usr/bin:/usr/ccs/bin export PATH
! #PATH=/usr/local/bin:/bin:/usr/bin:/usr/X11R6/bin export PATH
#
# each product MUST provide a $PRODUCT/admin/shrept.lst
```

10.6.5 Oracle-г ажиллуулах

Зааврудыг дагасны дараа та **Oracle**-г Линукс дээр ажиллуулж байгаа юм шиг ажиллуулж чадах ёстой.

10.7 SAP® R/3® суулгах нь

Хувь нэмэр болгон оруулсан Холгэр Кипп. Эх хувилбарыг SGML рүү хөрвүүлсэн Валентино Вашетто.

FreeBSD ашиглан **SAP** системүүдийг суулгах нь SAP-ийн дэмжих багаар дэмжигддэггүй —тэдгээр нь зөвхөн баталгаажсан тавцангуудын хувьд дэмжлэг санал болгодог.

10.7.1 Оршил

Энэ баримт нь FreeBSD болон **Oracle**-ийн суулгалтыг оруулаад Линуксд зориулсан **SAP R/3 System**-г **Oracle Database**-тэй цуг FreeBSD машин дээр суулгах боломжит аргыг тайлбарлах болно. Хоёр өөр тохиргоог тайлбарлана:

- FreeBSD 4.3-STABLE дээр **Oracle 8.0.5**-тай цуг **SAP R/3 4.6B (IDES)**
- FreeBSD 4.5-STABLE дээр **Oracle 8.1.7**-тай цуг **SAP R/3 4.6C**

Энэ баримт нь бүх чухал алхмуудыг илүү дэлгэрэнгүй тайлбарлахыг ороллдог ч гэсэн **Oracle** болон **SAP R/3**-ийн суулгалтын зааврууудыг орлох зорилгоор хийгдээгүй юм.

SAP-д зориулсан **SAP R/3** Линуксийн хувилбартай ирдэг баримтыг болон **Oracle**-тай холбоотой асуултууд, **Oracle** болон **SAP OSS**-ийн эх үүсвэрүүдийг үзнэ үү.

10.7.2 Програм хангамж

Дараах CD-ROM-ууд нь **SAP** суулгалтуудад ашиглагддаг:

10.7.2.1 SAP R/3 4.6B, Oracle 8.0.5

Нэр	Дугаар	Тайлбар
KERNEL	51009113	SAP Цөм Oracle / Суулгалт / AIX, Линукс, Solaris
RDBMS	51007558	Oracle / RDBMS 8.0.5.X / Линукс
EXPORT1	51010208	IDES / DB-Export / 6 Дискний 1-р Диск
EXPORT2	51010209	IDES / DB-Export / 6 Дискний 2-р Диск
EXPORT3	51010210	IDES / DB-Export / 6 Дискний 3-р Диск
EXPORT4	51010211	IDES / DB-Export / 6 Дискний 4-р Диск
EXPORT5	51010212	IDES / DB-Export / 6 Дискний 5-р Диск
EXPORT6	51010213	IDES / DB-Export / 6 Дискний 6-р Диск

Мөн бид **Oracle 8 Сервер** (Линуксийн Цөмийн Хувилбар 2.0.33-т зориулсан урьдчилсан хувилбар 8.0.5) CD-г ашигласан ба энэ нь тийм ч шаардлагатай биш бөгөөд бас FreeBSD 4.3-STABLE (4.3 RELEASE-с дөнгөж хэд хоног өнгөрч байсан) хувилбарыг ашигласан.

10.7.2.2 SAP R/3 4.6C SR2, Oracle 8.1.7

Нэр	Дугаар	Тайлбар
KERNEL	51014004	SAP Цөм Oracle / SAP Цөмийн Хувилбар 4.6D / DEC, Линукс
RDBMS	51012930	Oracle 8.1.7/ RDBMS / Линукс
EXPORT1	51013953	Хувилбар 4.6C SR2 / Export / 4 Дискний 1-р Диск

Нэр	Дугаар	Тайлбар
EXPORT1	51013953	Хувилбар 4.6C SR2 / Export / 4 Дискний 2-р Диск
EXPORT1	51013953	Хувилбар 4.6C SR2 / Export / 4 Дискний 3-р Диск
EXPORT1	51013953	Хувилбар 4.6C SR2 / Export / 4 Дискний 4-р Диск
LANG1	51013954	Хувилбар 4.6C SR2 / Хэл / DE, EN, FR / 3 Дискний 1-р Диск

Суулгахыг хүссэн хэлээс хамаарч хэлний нэмэлт CD-үүд хэрэг болж болох юм. Энд бид DE болон EN (Герман болон Англи) хэлүүдийг ашиглаж байгаа, тийм болохоор зөвхөн хэлний эхний CD хэрэгтэй юм. Тэмдэглэн хэлэхэд бүх дөрвөн EXPORT CD-үүдийн дугаар адил байна. Хэлний гурван CD-үүд бас адил дугаартай байна (энэ нь 4.6B IDES хувилбарын CD дугаарлалтаас өөр юм). Үүнийг бичиж байх үед суулгалт нь FreeBSD 4.5-STABLE (20.03.2002) хувилбар дээр ажиллаж байгаа болно.

10.7.3 SAP тэмдэглэлүүд

SAP R/3-ийг суулгахаасаа өмнө дараах тэмдэглэгээнүүдийг унших хэрэгтэй. Энэ нь бас суулгаж байх явцад ашигтай болох нь тогтоогдсон:

10.7.3.1 SAP R/3 4.6B, Oracle 8.0.5

Дугаар	Нэр
0171356	Линукс дээрх SAP програм хангамж: Үндсэн тайлбарууд
0201147	INST: UNIX - Oracle дээрх 4.6C R/3 Inst.
0373203	Шинэчлэл / Шилжүүлэлт Oracle 8.0.5 --> 8.0.6/8.1.6 ЛИНУКС
0072984	Oracle-д зориулсан Digital UNIX 4.0B Хувилбар
0130581	R3SETUP-ийн DIPGNTAB алхам зогсох
0144978	Таны систем зөв суулгагдаагүй байна
0162266	Windows NT / W2K дээрх R3SETUP-д зориулсан асуултууд болон зааврууд

10.7.3.2 SAP R/3 4.6C, Oracle 8.1.7

Дугаар	Нэр
0015023	Хүснэгт TCPDB (RSXP0004) (EBCDIC)-г эхлүүлэх
0045619	Хэд хэдэн хэлүүд болон үсгийн хэлбэрүүдтэй R/3
0171356	Линукс дээрх SAP програм хангамж: Үндсэн тайлбарууд

Дугаар	Нэр
0195603	RedHat 6.1 Enterprise хувилбар: Мэдэгдэж байгаа асуудлууд
0212876	Архивлах шинэ хэрэгсэл SAPCAR
0300900	Линукс: Гаргасан DELL тоног төхөөрөмж
0377187	RedHat 6.2: чухал тэмдэглэгээнүүд
0387074	INST: UNIX дээрх R/3 4.6C SR2 суулгалт
0387077	INST: UNIX - Oracle дээрх R/3 4.6C SR2 Inst.
0387078	UNIX дээрх SAP програм хангамж: OS-ийн хамаарлууд 4.6C SR2

10.7.4 Тоног төхөөрөмжийн шаардлагууд

SAP R/3 System-ийн суулгалтад дараах төхөөрөмжүүд хангалттай. Үйлдвэрлэлийн зорилгоор ашиглахад мэдээж илүү тодорхой хэмжээнүүд шаардлагатай:

Бүрэлдэхүүн	4.6B	4.6C
Процессор	2 x 800MHz Pentium III	2 x 800MHz Pentium III
Санах ой	1GB ECC	2GB ECC
Хатуу дискний зай	50-60GB (IDES)	50-60GB (IDES)

Үйлдвэрлэлд том кэш, өндөр хурдтай дискний хандалт (SCSI, RAID тоног төхөөрөмжийн хянагч), USV болон ECC-RAM бүхий Xeon процессоруудыг ашиглахыг зөвлөдөг. Хатуу дискний их хэмжээний зай нь суулгах явцад 27 GB хэмжээтэй мэдээллийн баазын файлуудыг үүсгэдэг урьдчилан тохируулсан IDES системээс болдог. Энэ зай нь эхний үйлдвэрлэлийн систем болон програмын өгөгдлүүдэд бас хангалттай байдаг.

10.7.4.1 SAP R/3 4.6B, Oracle 8.0.5

Дараах тоног төхөөрөмж ашиглагдсан: 2 ширхэг 800 MHz Pentium III процессор бүхий хоёр процессор суулгаж болох хавтан, 29160 Ultra160 SCSI адаптер (40/80 GB DLT соронзон хальсны хөтөч болон CDROM-д хандахын тулд) Mylex® AcceleRAID™ (2 суваг, 32 MB RAM-тай firmware 6.00-1-00) ашиглагдсан. Mylex RAID хянагч уруу хоёр 17 GB хатуу диск (толин тусгал хийгдсэн) болон дөрвөн 36 GB хатуу диск (RAID түвшин 5) залгагдсан болно.

10.7.4.2 SAP R/3 4.6C, Oracle 8.1.7

Энэ суулгалтад Dell™ PowerEdge™ 2500 ашиглагдсан: хоёр 1000 MHz Pentium III процессор (256 kB Кэш) бүхий хоёр процессор суулгаж болох хавтан, 2 GB PC133 ECC SDRAM, 128 MB санах ойтой PERC/3 DC PCI RAID Хянагч болон EIDE DVD-ROM хөтөч ашиглагдсан. RAID хянагч уруу хоёр 18 GB хатуу диск (толин тусгал хийгдсэн) болон дөрвөн 36 GB хатуу диск (RAID түвшин 5) залгагдсан болно.

10.7.5 FreeBSD-ийн суулгалт

Та эхлээд FreeBSD суулгах хэрэгтэй. Үүнийг хийх хэд хэдэн арга байгаа бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг Section 2.13-с уншина уу.

10.7.5.1 Дискний дүр зураг

Хялбар байлгахын тулд ижил дискний байршлыг **SAP R/3 46B** болон **SAP R/3 46C SR2** суулгалтад хэрэглэсэн. Суулгалт өөр өөр тоног төхөөрөмжин (`/dev/da` болон `/dev/amr`, тэгэхээр хэрэв AMI MegaRAID®-г ашиглаж байгаа бол `/dev/da0s1a`-ийн оронд `/dev/amr0s1a`-г харах болно) дээр хийгдсэн болохоор зөвхөн төхөөрөмжийн нэрс өөрчлөгдсөн:

Файлын систем	Хэмжээ (1k-блок)	Хэмжээ (GB)	Холбогдсон газар
`/dev/da0s1a`	1.016.303	1	`/`
`/dev/da0s1b`		6	swap
`/dev/da0s1e`	2.032.623	2	`/var`
`/dev/da0s1f`	8.205.339	8	`/usr`
`/dev/da1s1e`	45.734.361	45	`/compat/linux/oracle`
`/dev/da1s1f`	2.032.623	2	`/compat/linux/sapmnt`
`/dev/da1s1g`	2.032.623	2	`/compat/linux/usr/sap`

Урьдаар Mylex юм уу эсвэл PERC/3 RAID програм хангамжаар хоёр логик хөтчийг тохируулж эхлүүлэх хэрэгтэй. Програм хангамж нь BIOS-ийн ачаалах үед эхлүүлэгдэж болдог.

Энэхүү дискний байршил нь SAP-ийн зөвлөдгөөс шал ондоо байгааг санаарай. SAP нь **Oracle** дэд сангуудыг (болон бусад заримыг) тусад нь холбохыг санал болгодог — бид хялбар байх үүднээс тэдгээрийг жинхэнэ дэд сангууд маягаар үүсгэхээр шийдсэн юм.

10.7.5.2 `make world` болон шинэ цөм

Хамгийн сүүлийн -STABLE эхийг татаж авах хэрэгтэй. Өөрийн цөмийн тохиргооны файлаа тохируулсны дараа ертөнц болон өөрийн өөрчлөгдсөн цөмөө дахин бүтээх хэрэгтэй. Энд та бас **SAP R/3** болон **Oracle**-ийн шаарддаг цөмийн параметрүүдийг оруулах хэрэгтэй.

10.7.6 Линуксийн орчныг суулгах

10.7.6.1 Линуксийн үндсэн системийн суулгах

Эхлээд linux_base портыг суулгах хэрэгтэй (`root` эрхээр):

```
# cd /usr/ports/emulators/linux_base-fc4
# make install distclean
```

10.7.6.2 Линуксийн хөгжүүлэлтийн орчинг суулгах

Section 10.6-д дурдсаны дагуу FreeBSD дээр **Oracle**-г суулгахыг хүсэж байгаа бол Линуксийн хөгжүүлэлтийн орчин хэрэгтэй:

```
# cd /usr/ports/devel/linux_devtools
# make install distclean
```

Линуксийн хөгжүүлэлтийн орчин зөвхөн **SAP R/3 46B IDES** суулгалтад зориулагдан суугдсан. **Oracle DB** нь FreeBSD систем дээр дахин холбоос хийгдээгүй бол энэ нь шаардлагагүй юм. Линукс системээс **Oracle**-ийн tar бөмбөгийг ашиглаж байгаа тохиолдол нь энэ юм.

10.7.6.3 Шаардлагатай RPM-үүдийг суулгах

`R3SETUP` програмыг эхлүүлэхийн тулд PAM дэмжлэг хэрэгтэй. FreeBSD 4.3-STABLE дээрх эхний **SAP** суулгалтын үед бид PAM-ийг шаардлагатай бүх багцуудтай нь суулгахыг оролдсон бөгөөд эцэст нь PAM багцын суулгалтыг хийсэн юм. Үүний дүнд энэ нь ажилласан. **SAP R/3 4.6C SR2**-ийн хувьд бид PAM RPM-ийн суулгалтыг шууд хийсэн ба энэ нь бас ажилласан юм. Тийм болохоор хамааралтай багцууд хэрэггүй байх:

```
# rpm -i --ignoreos --nodeps --root /compat/linux --dbpath /var/lib/rpm \
pam-0.68-7.i386.rpm
```

Oracle 8.0.5-ийн хувьд ухаалаг агентийг ажиллуулахын тулд бид RedHat Tcl багц `tcl-8.0.5-30.i386.rpm`-г суулгах хэрэгтэй болсон (тэгэхгүй бол **Oracle**-г суулгах явцад дахин холбоос үүсгэлт ажиллахгүй болно). **Oracle**-ийн дахин холбоос үүсгэлтийн талаар бусад зарим асуудлууд байдаг боловч энэ нь FreeBSD-тэй холбоотой биш **Oracle** Линуксийн асуудал юм.

10.7.6.4 Зарим нэгэн нэмэлт зөвлөмжүүд

`linprocfs`-г `/etc/fstab` уруу нэмэх нь сайн санаа байж болох бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг linprocfs(5) гарын авлагын хуудаснаас үзнэ үү. Тохируулах өөр нэг параметр нь `/etc/sysctl.conf`-д хийгддэг `kern.fallback_elf_brand=3` тохиргоо юм.

10.7.7 SAP R/3 орчинг үүсгэх

10.7.7.1 Шаардлагатай файлын системүүд болон холболтын цэгүүдийг үүсгэх

Хялбар суулгалтын хувьд дараах файлын системүүдийг үүсгэхэд хангалттай:

холбох цэг	хэмжээ GB
`/compat/linux/oracle`	45 GB
`/compat/linux/sapmnt`	2 GB
`/compat/linux/usr/sap`	2 GB

Зарим нэгэн холбоосуудыг бас үүсгэх шаардлагатай. Тэгэхгүй бол **SAP** суулгагч холбоосуудыг шалгаж гомдоллох болно:

```
# ln -s /compat/linux/oracle /oracle
# ln -s /compat/linux/sapmnt /sapmnt
# ln -s /compat/linux/usr/sap /usr/sap
```

Суулгалтын явц дахь болзошгүй алдааны мэдэгдэл (энд Систем *PRD* болон **SAP R/3 4.6C SR2** суулгалттай цуг):

```
INFO 2002-03-19 16:45:36 R3LINKS_IND_IND SyLinkCreate:200
    Checking existence of symbolic link /usr/sap/PRD/SYS/exe/dbg to
    /sapmnt/PRD/exe. Creating if it does not exist...

WARNING 2002-03-19 16:45:36 R3LINKS_IND_IND SyLinkCreate:400
    Link /usr/sap/PRD/SYS/exe/dbg exists but it points to file
    /compat/linux/sapmnt/PRD/exe instead of /sapmnt/PRD/exe. The
    program cannot go on as long as this link exists at this
    location. Move the link to another location.

ERROR 2002-03-19 16:45:36 R3LINKS_IND_IND Ins_SetupLinks:0
    can not setup link '/usr/sap/PRD/SYS/exe/dbg' with content
    '/sapmnt/PRD/exe'
```

10.7.7.2 Хэрэглэгчид болон сангуудыг үүсгэх

SAP R/3-д хоёр хэрэглэгч болон гурван бүлэг хэрэгтэй. Хэрэглэгчийн нэрс гурван үсгээс тогтох **SAP** системийн ID-с (SID) хамаарна. Эдгээр SID-үүдийн зарим нь **SAP**-р нөөцлөгдсөн (жишээ нь `SAP` болон `NIX`. Бүрэн жагсаалтын талаар дэлгэрэнгүйг **SAP**-ийн баримтаас үзнэ үү). IDES суулгалтын хувьд бид `IDS`-г 4.6C SR2 суулгалтын хувьд систем нь үйлдвэрлэлийн хэрэглээнд зориулагдсан болохоор `PRD`-г ашигласан. Тиймээс бид дараах бүлгүүдтэй байна (бүлгийн ID-ууд өөр байж болох бөгөөд эдгээр нь ердөө л бидний суулгалтандаа ашигласан утгууд юм):

бүлгийн ID	бүлгийн нэр	тайлбар
100	dba	Data Base Administrator буюу Өгөгдлийн Баазын Администратор
101	sapsys	SAP Систем
102	oper	Өгөгдлийн Баазын Оператор

Анхдагч **Oracle** суулгалтын хувьд зөвхөн `dba` бүлэг ашиглагдана. `oper` бүлэг маягаар `dba` бүлгийг бас зарим нь ашигладаг (илүү мэдээллийг **Oracle** болон **SAP** баримтаас үзнэ үү).

Бидэнд бас дараах хэрэглэгчид хэрэгтэй:

хэрэглэгчийн ID	хэрэглэгчийн нэр	ерөнхий нэр	бүлэг	нэмэлт бүлгүүд	тайлбар
1000	idsadm/prdadm	*sid*adm	sapsys	oper	SAP администратор
1002	oraids/oraprd	ora*sid*	dba	oper	Oracle администратор

adduser(8)-ээр хэрэглэгчид нэмэх нь “SAP администратор”ын хувьд дараах (бүрхүүл болон гэрийн сан гэдгийг санаарай) оруулгуудыг шаарддаг:

```
Name: sidadm
Password: ******
Fullname: SAP Administrator SID
Uid: 1000
Gid: 101 (sapsys)
Class:
Groups: sapsys dba
HOME: /home/sidadm
Shell: bash  (/compat/linux/bin/bash)
```

бөгөөд “Oracle администратор”ын хувьд:

```
Name: orasid
Password: ******
Fullname: Oracle Administrator SID
Uid: 1002
Gid: 100 (dba)
Class:
Groups: dba
HOME: /oracle/sid
Shell: bash  (/compat/linux/bin/bash)
```

`dba` болон `oper` бүлгүүдийг хоёуланг та ашиглаж байгаа бол энэ нь бас `oper` бүлгийг оруулсан байх ёстой.

10.7.7.3 Сангуудыг үүсгэх

Эдгээр сангууд нь тусдаа файлын системүүд маягаар ихэвчлэн үүсгэгддэг. Таны шаардлагуудаас энэ нь шууд хамаарах юм. Тэдгээр нь бүгд нэг RAID 5 дээр байрлаж байгаа болохоор бид тэдгээрийг энгийн сангууд маягаар үүсгэхээр сонгосон юм:

Эхлээд бид зарим сангуудын эзэмшигчид болон эрхүүдийг тохируулна (`root` хэрэглэгчээр):

```
# chmod 775 /oracle
# chmod 777 /sapmnt
# chown root:dba /oracle
# chown sidadm:sapsys /compat/linux/usr/sap
# chmod 775 /compat/linux/usr/sap
```

Дараа нь бид сангуудыг `orasid` хэрэглэгчээр үүсгэнэ. Эдгээр нь бүгдээрээ `/oracle/SID`-ийн дэд сангууд байх болно:

```
# su - orasid
# cd /oracle/SID
# mkdir mirrlogA mirrlogB origlogA origlogB
# mkdir sapdata1 sapdata2 sapdata3 sapdata4 sapdata5 sapdata6
# mkdir saparch sapreorg
# exit
```

Oracle 8.1.7 суулгалтын хувьд зарим нэгэн нэмэлт сангууд хэрэгтэй:

```
# su - orasid
# cd /oracle
# mkdir 805_32
# mkdir client stage
# mkdir client/80x_32
# mkdir stage/817_32
# cd /oracle/SID
# mkdir 817_32
```

> **Note:** `client/80x_32` сан яг энэ нэртэйгээр ашиглагддаг. *X*-г ямар нэгэн тоо юм уу эсвэл өөр зүйлээр битгий солиорой.

Гурав дахь шатанд бид *sid*adm хэрэглэгчээр сангуудыг үүсгэнэ:

```
# su - sidadm
# cd /usr/sap
# mkdir SID
# mkdir trans
# exit
```

10.7.7.4 /etc/services файл дахь оруулгууд

SAP R/3 нь `/etc/services` файлд зарим нэгэн оруулгуудыг шаарддаг бөгөөд FreeBSD дээр суулгаж байх явцад зөвөөр тохируулагддаггүй. Дараах оруулгуудыг нэмнэ үү (танд хамгийн багадаа тохиолдлын дугаартай тохирох оруулгууд хэрэгтэй. Энэ тохиолдолд `00` байна. Бүх оруулгуудыг `00`-с эхлээд `99` хүртэл `dp`, `gw`, `sp` болон `ms`-т зориулж нэмэх нь аюулгүй юм). Хэрэв та **SAProuter** юм уу эсвэл **SAP** OSS-т хандах хэрэгтэй болвол танд бас `99` хэрэгтэй болох бөгөөд учир нь порт 3299 нь систем дээрх **SAProuter** процессийн хувьд ихэвчлэн ашиглагддаг:

```
sapdp00    3200/tcp # SAP Dispatcher.      3200 + Instance-Number
sapgw00  3300/tcp # SAP Gateway.         3300 + Instance-Number
sapsp00  3400/tcp #                      3400 + Instance-Number
sapms00  3500/tcp #                      3500 + Instance-Number
sapmsSID 3600/tcp # SAP Message Server.  3600 + Instance-Number
sapgw00s   4800/tcp # SAP Secure Gateway   4800 + Instance-Number
```

10.7.7.5 Шаардлагатай локалууд

SAP нь анхдагч RedHat суулгацад байдаггүй хоёр локалыг хамгийн багадаа шаарддаг. SAP нь шаардлагатай RPM-үүдийг тэдгээрийн FTP серверээс (хэрэв та OSS хандалттай үйлчлүүлэгч бол энэ нь хандах боломжтой байна) татаж авах боломжтойгоор санал болгодог. Хэрэгтэй RPM-үүдийн жагсаалтын талаар 0171356 тэмдэглэгээг үзнэ үү.

Ердөө л тохирох холбоосуудыг (жишээ нь *de_DE* болон *en_US*-с) үүсгэх бас боломжтой байдаг боловч бид үүнийг үйлдвэрлэлийн систем дээр зөвлөдөггүй (гэхдээ энэ нь IDES системтэй одоогоор ямар ч асуудалгүй ажилласан). Дараах локалууд хэрэгтэй:

```
de_DE.ISO-8859-1
```

```
en_US.ISO-8859-1
```

Үүнтэй адил холбоосуудыг үүсгэнэ:

```
# cd /compat/linux/usr/share/locale
# ln -s de_DE de_DE.ISO-8859-1
# ln -s en_US en_US.ISO-8859-1
```

Хэрэв тэдгээр нь байхгүй бол суулгацын явцад зарим асуудлууд гарах болно. Хэрэв эдгээрийг тэгээд дараа нь (зөрчиж байгаа алхмуудын `STATUS`-г `OK` болгон `CENTRDB.R3S` файлд тохируулж) дахин орхигдуулбал зарим нэг нэмэлт оролдлогогүйгээр **SAP** систем уруу нэвтрэн орох боломжгүй болно.

10.7.7.6 Цөмийг тааруулах

SAP R/3 системүүд нь маш их эх үүсвэрүүд шаарддаг. Тийм болохоор бид дараах параметрүүдийг цөмийн тохиргооны файлд нэмсэн билээ:

```
# Set these for memory pigs (SAP and Oracle):
options MAXDSIZ="(1024*1024*1024)"
options DFLDSIZ="(1024*1024*1024)"
# System V options needed.
options SYSVSHM #SYSV-style shared memory
options SHMMAXPGS=262144 #max amount of shared mem. pages
#options SHMMAXPGS=393216 #use this for the 46C inst.parameters
options SHMMNI=256 #max number of shared memory ident if.
options SHMSEG=100 #max shared mem.segs per process
options SYSVMSG #SYSV-style message queues
options MSGSEG=32767 #max num. of mes.segments in system
options MSGSSZ=32 #size of msg-seg. MUST be power of 2
options MSGMNB=65535 #max char. per message queue
options MSGTQL=2046 #max amount of msgs in system
options SYSVSEM #SYSV-style semaphores
options SEMMNU=256 #number of semaphore UNDO structures
options SEMMNS=1024 #number of semaphores in system
options SEMMNI=520 #number of semaphore identifiers
options SEMUME=100       #number of UNDO keys
```

SAP-с ирсэн баримтан дээр хамгийн бага утгуудыг заасан байдаг. Линуксд зориулсан тайлбар байдаггүй учраас илүү мэдээллийг HP-UX хэсгээс (32-бит) үзнэ үү. 4.6C SR2 суулгацад зориулсан систем нь илүү их гол санах ойтой болохоор хуваалцсан сегмент нь **SAP** болон **Oracle**-ийн хувьд илүү том байж болох юм. Тийм болохоор илүү их тооны хуваалцсан санах ойн хуудсуудыг сонгох хэрэгтэй.

> **Note:** i386 дээрх FreeBSD-ийн анхдагч суулгалтад `MAXDSIZ` болон `DFLDSIZ`-г хамгийн ихдээ 1 GB болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол “`ORA-27102: out of memory`” болон “`Linux Error: 12: Cannot allocate memory`” зэрэг хачирхалтай алдаанууд гарч болзошгүй юм.

10.7.8 SAP R/3-г суулгах

10.7.8.1 SAP CDROM-уудыг бэлтгэх

Суулгалтын явцад олон CDROM-уудыг холбож, салгах болдог. Таныг олон CDROM хөтчүүдтэй гэж үзвэл та тэдгээрийг бүгдийг холбож болох юм. Бид CDROM-уудын агуулгыг харгалзах сангуудад хуулахаар шийдсэн юм:

`/oracle/SID/sapreorg/cd-name`

Энд байгаа *cd-name* нь 4.6B/IDES суулгацын хувьд `KERNEL`, `RDBMS`, `EXPORT1`, `EXPORT2`, `EXPORT3`, `EXPORT4`, `EXPORT5` болон `EXPORT6` дискнүүдийн аль нэг бөгөөд 4.6C SR2 суулгацын хувьд `KERNEL`, `RDBMS`, `DISK1`, `DISK2`, `DISK3`, `DISK4` болон `LANG` дискнүүдийн аль нэг байна. Холбогдсон CD-үүд дээрх бүх файлын нэрс томоор байх ёстой, аль эсвэл холболт хийхдээ `-g` тохируулгыг ашиглах хэрэгтэй. Тийм болохоор дараах тушаалуудыг ашиглах хэрэгтэй:

```
# mount_cd9660 -g /dev/cd0a /mnt
# cp -R /mnt/* /oracle/SID/sapreorg/cd-name
# umount /mnt
```

10.7.8.2 Суулгалтын скриптийг ажиллуулах

Эхлээд та `install` санг бэлдэх хэрэгтэй:

```
# cd /oracle/SID/sapreorg
# mkdir install
# cd install
```

Тэгээд суулгах скрипт эхлэх бөгөөд бүх холбоотой файлуудыг `install` сан уруу хуулах болно:

```
# /oracle/SID/sapreorg/KERNEL/UNIX/INSTTOOL.SH
```

IDES суулгац (4.6B) нь бүрэн өөрчлөн тохируулагдсан SAP R/3 үзүүлэх системтэй ирдэг болохоор гурван EXPORT CD-ний оронд зургаа байдаг. Энэ үед суулгах загвар `CENTRDB.R3S` нь IDES төв тохиолдолд зориулагдаагүй харин стандарт төв тохиолдлын (**R/3** болон мэдээллийн бааз) хувьд зориулагдсан байх учраас `EXPORT1` сангийн харгалзах `CENTRDB.R3S` файлыг хуулах хэрэгтэй бөгөөд тэгэхгүй бол `R3SETUP` тушаал зөвхөн гурван EXPORT CD-г асуух болно.

Шинэ **SAP 4.6C SR2** хувилбар дөрвөн EXPORT CD-тэй ирдэг. Суулгалтын алхмуудыг хянадаг параметрийн файл нь `CENTRAL.R3S` байна. Өмнөх хувилбаруудтай харьцуулах юм бол мэдээллийн баазтай эсвэл баазгүй төв тохиолдолд зориулагдсан суулгалтын тусдаа загвар байдаггүй. **SAP** нь мэдээллийн баазын суулгацад зориулж тусдаа загвар ашиглаж байна. Суулгалтыг дараа нь дахин эхлүүлэхийн тулд анхны файлтай дахин эхлүүлэх нь хангалттай байдаг.

Суулгалтын үед болон дараа **SAP** нь `hostname` тушаалаас бүрэн танигдсан домэйн нэрийг биш зөвхөн компьютерийн нэрийг буцаахыг шаарддаг. Хостын нэрийг тааруулах юм уу эсвэл `ora`*sid* болон *sid*`adm` (болон `root` хэрэглэгчээр хийсэн суулгалтын алхмуудын үед ядаж `root`) хэрэглэгчдэд зориулж `alias hostname='hostname -s'` тушаалаар alias буюу өөр нэрийг тохируулах хэрэгтэй. **SAP** суулгацын үед суулгагдсан хоёр хэрэглэгчийн `.profile` болон `.login` файлуудыг тааруулах боломж бас байдаг.

10.7.8.3 R3SETUP 4.6B-г эхлүүлнэ

LD_LIBRARY_PATH зөв тохируулагдсан эсэхийг шалгаарай:

```
# export LD_LIBRARY_PATH=/oracle/IDS/lib:/sapmnt/IDS/exe:/oracle/805_32/lib
```

Суулгалтын сангаас R3SETUP тушаалыг root эрхээр эхлүүлнэ:

```
# cd /oracle/IDS/sapreorg/install
# ./R3SETUP -f CENTRDB.R3S
```

Дараа нь скрипт зарим асуултууд асууна (хаалтанд анхдагчид байх бөгөөд оролт үүний дараа хийгдэнэ):

Асуулт	Анхдагч	Оролт
Enter SAP System ID	[C11]	IDS**Enter**
Enter SAP Instance Number	[00]	**Enter**
Enter SAPMOUNT Directory	[/sapmnt]	**Enter**
Enter name of SAP central host	[troubadix.domain.de]	**Enter**
Enter name of SAP db host	[troubadix]	**Enter**
Select character set	[1] (WE8DEC)	**Enter**
Enter Oracle server version (1) Oracle 8.0.5, (2) Oracle 8.0.6, (3) Oracle 8.1.5, (4) Oracle 8.1.6		1**Enter**
Extract Oracle Client archive	[1] (Yes, extract)	**Enter**
Enter path to KERNEL CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/KERNEL
Enter path to RDBMS CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/RDBMS
Enter path to EXPORT1 CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/EXPORT1
Directory to copy EXPORT1 CD	[/oracle/IDS/sapreorg/CD4_DIR]	**Enter**
Enter path to EXPORT2 CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/EXPORT2
Directory to copy EXPORT2 CD	[/oracle/IDS/sapreorg/CD5_DIR]	**Enter**
Enter path to EXPORT3 CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/EXPORT3
Directory to copy EXPORT3 CD	[/oracle/IDS/sapreorg/CD6_DIR]	**Enter**
Enter path to EXPORT4 CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/EXPORT4
Directory to copy EXPORT4 CD	[/oracle/IDS/sapreorg/CD7_DIR]	**Enter**
Enter path to EXPORT5 CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/EXPORT5
Directory to copy EXPORT5 CD	[/oracle/IDS/sapreorg/CD8_DIR]	**Enter**
Enter path to EXPORT6 CD	[/sapcd]	/oracle/IDS/sapreorg/EXPORT6
Directory to copy EXPORT6 CD	[/oracle/IDS/sapreorg/CD9_DIR]	**Enter**
Enter amount of RAM for SAP + DB		850**Enter** (in Megabytes)
Service Entry Message Server	[3600]	**Enter**
Enter Group-ID of sapsys	[101]	**Enter**
Enter Group-ID of oper	[102]	**Enter**
Enter Group-ID of dba	[100]	**Enter**

Асуулт	Анхдагч	Оролт
Enter User-ID of *sid*adm	[1000]	**Enter**
Enter User-ID of ora*sid*	[1002]	**Enter**
Number of parallel procs	[2]	**Enter**

Хэрэв та CD-үүдийг өөр байрлалууд уруу хуулаагүй бол **SAP** суулгагч хэрэгтэй CD-гээ (CD дээрх `LABEL.ASC` файлаар танигддаг) олж чадахгүй бөгөөд танаас CD-г хийн холбож холбох цэгийг оруулахыг асуух болно.

`CENTRDB.R3S` нь алдаатай байж болох юм. Бидний тохиолдолд энэ нь EXPORT4 CD-г дахин хүсэх боловч зөв түлхүүрийг үзүүлсэн (6_LOCATION, дараа нь 7_LOCATION гэх мэт.), тэгэхээр зөв утгуудыг оруулан үргэлжлүүлж болох юм.

Доор дурдсан зарим асуудлуудыг тооцохгүй юм бол бүгд Oracle мэдээллийн баазын програм хангамжийг суулгах хэрэгтэй болох хүртэл шулуун явах ёстой.

10.7.8.4 `R3SETUP` 4.6C SR2-г эхлүүлнэ

`LD_LIBRARY_PATH` зөв тохируулагдсан эсэхийг шалгаарай. Энэ нь **Oracle 8.0.5**-тай 4.6B суулгацаас өөр утга байна:

```
# export LD_LIBRARY_PATH=/sapmnt/PRD/exe:/oracle/PRD/817_32/lib
```

Суулгалтын сангаас `R3SETUP` тушаалыг `root` хэрэглэгчээр эхлүүлнэ:

```
# cd /oracle/PRD/sapreorg/install
# ./R3SETUP -f CENTRAL.R3S
```

Дараа нь скрипт зарим асуултууд асууна (хаалтанд анхдагчид байх бөгөөд оролт үүний дараа хийгдэнэ):

Асуулт	Анхдагч	Оролт
Enter SAP System ID	[C11]	PRD**Enter**
Enter SAP Instance Number	[00]	**Enter**
Enter SAPMOUNT Directory	[/sapmnt]	**Enter**
Enter name of SAP central host	[majestix]	**Enter**
Enter Database System ID	[PRD]	PRD**Enter**
Enter name of SAP db host	[majestix]	**Enter**
Select character set	[1] (WE8DEC)	**Enter**
Enter Oracle server version (2) Oracle 8.1.7		2**Enter**
Extract Oracle Client archive	[1] (Yes, extract)	**Enter**
Enter path to KERNEL CD	[/sapcd]	/oracle/PRD/sapreorg/KERNEL
Enter amount of RAM for SAP + DB	2044	1800**Enter** (in Megabytes)
Service Entry Message Server	[3600]	**Enter**
Enter Group-ID of sapsys	[100]	**Enter**

Асуулт	Анхдагч	Оролт
Enter Group-ID of oper	[101]	**Enter**
Enter Group-ID of dba	[102]	**Enter**
Enter User-ID of `oraprd`	[1002]	**Enter**
Enter User-ID of `prdadm`	[1000]	**Enter**
LDAP support		3**Enter** (no support)
Installation step completed	[1] (continue)	**Enter**
Choose installation service	[1] (DB inst,file)	**Enter**

Суулгалтын явцад OSUSERDBSID_IND_ORA (`ora`*`sid`* хэрэглэгчийг үүсгэх) үе болон OSUSERSIDADM_IND_ORA (*`sid`*`adm` хэрэглэгчийг үүсгэх) үед хэрэглэгчдийг үүсгэхэд алдаа өгч байна.

Доор дурдсан зарим асуудлуудыг тооцохгүй юм бол бүгд Oracle мэдээллийн баазын програм хангамжийг суулгах хэрэгтэй болох хүртэл шулуун явах ёстой.

10.7.9 Oracle 8.0.5-г суулгах

Линукс болон **Oracle DB**-ийн болзошгүй асуудлуудын талаар харгалзах SAP-ийн тэмдэглэгээнүүд болон Oracle-ийн `Readme` файлуудыг үзнэ үү. Бүх асуудлуудын ихэнх нь нийцгүй сангуудаас болдог.

Oracle суулгах тухай дэлгэрэнгүй мэдээллийг Oracle суулгах нь бүлгээс лавлана уу.

10.7.9.1 Oracle 8.0.5-г `orainst`-ээр суулгах

Хэрэв **Oracle 8.0.5** ашиглагдах болвол амжилттай дахин холбоход зарим нэмэлт сангууд хэрэгтэй. **Oracle 8.0.5** нь хуучин glibc-тэй (RedHat 6.0) холбогдсон байдаг болохоор тэр юм. Гэхдээ RedHat 6.1 нь шинэ glibc ашигладаг. Тэгэхээр холболт ажиллахыг баталгаажуулахын тулд та дараах нэмэлт багцуудыг суулгах хэрэгтэй:

- `compat-libs-5.2-2.i386.rpm`
- `compat-glibc-5.2-2.0.7.2.i386.rpm`
- `compat-egcs-5.2-1.0.3a.1.i386.rpm`
- `compat-egcs-c++-5.2-1.0.3a.1.i386.rpm`
- `compat-binutils-5.2-2.9.1.0.23.1.i386.rpm`

Цаашхи мэдээллийн талаар харгалзах SAP-ийн тэмдэглэгээнүүд болон Oracle-ийн `Readme` файлуудыг үзнэ үү. Хэрэв энэ нь сонголт биш бол (суулгах явцад бидэнд үүнийг шалгах хангалттай хугацаа байгаагүй) анхны хоёртын файлууд юм уу эсвэл анхны RedHat системээс дахин холбогдсон хоёртын файлуудыг ашиглаж болох юм.

Ухаалаг агентийг эмхэтгэхийн тулд RedHat Tcl багц суулгагдсан байх ёстой. Хэрэв та `tcl-8.0.3-20.i386.rpm` файлыг авч чадахгүй байгаа бол RedHat 6.1-д зориулагдсан `tcl-8.0.5-30.i386.rpm` зэрэг шинэ бас байж болох юм.

Дахин холбохоос бусдаараа суулгалт нь шулуухан юм:

```
# su - oraids
```

```
# export TERM=xterm
# export ORACLE_TERM=xterm
# export ORACLE_HOME=/oracle/IDS
# cd $ORACLE_HOME/orainst_sap
# ./orainst
```

Програм хангамж суулгагдах хүртэл бүх дэлгэц дээр байгааг **Enter** дарж баталгаажуулах хэрэгтэй. Гэхдээ *Oracle On-Line Text Viewer* гэдгийг сонгосноо болиулах хэрэгтэй, учир нь энэ нь Линукс дээр байдаггүй. **Oracle** дараа нь байгаа `gcc`, `egcs` болон `i386-redhat-linux-gcc -`үүдийн оронд `i386-glibc20-linux-gcc`-ээр дахин холбогдохыг хүсдэг.

Хугацаанаас болоод бид **Oracle 8.0.5 PreProduction** хувилбарын хоёртын файлуудыг ашиглахаар шийдсэн юм. Учир нь тэр үед RDBMS CD-ээс хувилбарыг ажиллуулах эхний оролдлого амжилтгүй болсон, бас зөв RPM-үүдийг олж тэдгээрт хандах нь аймшгийн хар дарсан зүүд шиг байсан зэргээс болсон юм.

10.7.9.2 Линуксд (Цөм 2.0.33) зориулсан Oracle 8.0.5 Pre-production Release-г суулгах

Энэ суулгалт нь их амархан. CD-г холбож суулгагчийг эхлүүлнэ. Энэ нь Oracle-ийн гэрийн сангийн байрлалыг асуух бөгөөд бүх хоёртын файлуудыг тэнд хуулах болно. Гэхдээ бид өөрсдийн өмнөх RDBMS суулгалтын файлуудын үлдэгдлүүдийг устгаагүй болно.

Дараа нь **Oracle** мэдээллийн баазыг ямар ч асуудалгүйгээр эхлүүлж болно.

10.7.10 Oracle 8.1.7 Линуксийн tar бөмбөгийг суулгах

Линукс систем дээрх суулгалтын сангаас үүсгэсэн `oracle81732.tgz` tar бөмбөгөө аваад `/oracle/`*`SID`*`/817_32/` уруу буцааж задлах хэрэгтэй.

10.7.11 SAP R/3-ийн суулгацыг үргэлжлүүлэх

Эхлээд `idsamd` (*`sid`*adm) болон `oraids` (ora*`sid`*) хэрэглэгчдийн орчны тохиргоонуудыг шалгах хэрэгтэй. Тэдгээр нь одоо бүгд `hostname` тушаалыг ашиглаж байгаа `.profile`, `.login` болон `.cshrc` файлуудтай байх ёстой. Системийн хостын нэр бүрэн танигдах нэр бол та `hostname` тушаалыг `hostname -s` тушаалаар бүх гурван файл дотор өөрчлөх хэрэгтэй.

10.7.11.1 Мэдээллийн баазыг дуудах

Дараа нь `R3SETUP` тушаалыг дахин эхлүүлэх юм уу эсвэл үргэлжлүүлж болно (гарахыг сонгосон эсэхээс хамаарч). `R3SETUP` нь дараа нь хүснэгтийн талбаруудыг үүсгэж өгөгдлийг (46B IDES-ийн хувьд EXPORT1-с EXPORT6, 46C-ийн хувьд DISK1-с DISK4) мэдээллийн бааз уруу `R3load` тушаалаар дуудна.

Мэдээллийн бааз дуудагдаж дууссаны дараа (хэдэн цаг болж болно) зарим нууц үгсийг асуудаг. Тест суулгалтуудад хүн бүхний мэддэг анхдагч нууц үгсийг ашиглаж болох юм (хэрэв аюулгүй байдал чухал бол өөрийг ашиглаарай!):

Асуулт	Оролт
Enter Password for sapr3	sap**Enter**

Асуулт	Оролт
Confirum Password for sapr3	sap**Enter**
Enter Password for sys	change_on_install**Enter**
Confirm Password for sys	change_on_install**Enter**
Enter Password for system	manager**Enter**
Confirm Password for system	manager**Enter**

Энэ үед бид 4.6B суулгаж байх явцад `dipgntab` тушаалын хувьд цөөн асуудлуудтай тулгарсан.

10.7.11.2 Сонсогч

Oracle сонсогчийг `ora`*`sid`* хэрэглэгчээр дараах маягаар эхлүүлнэ:

```
% umask 0; lsnrctl start
```

Тэгэхгүй бол сокетууд нь зөв зөвшөөрлүүдгүй байх учраас ORA-12546 алдааг та харж болох юм. SAP Тэмдэглэгээ 072984-г үзнэ үү.

10.7.11.3 MNLS хүснэгтүүдийг шинэчлэх

Хэрэв та Latin-1 биш хэлүүдийг **SAP** систем уруу импорт хийхээр төлөвлөж байгаа бол Multi National Language Support хүснэгтүүд буюу Олон Үндэстний Хэлний Дэмжлэгийн хүснэгтүүдийг шинэчлэх хэрэгтэй. Энэ нь SAP OSS Тэмдэглэгээнүүд 15023 болон 45619-д тайлбарлагдсан байгаа. Үгүй бол энэ асуултыг **SAP** суулгалтын явцад орхиж болно.

> **Note:** Хэрэв танд MNLS хэрэггүй бол хүснэгт TCPDB-г шалгаж эхлүүлэлт хийгдээгүй бол эхлүүлэх шаардлага хэвээр байсаар байх болно. Дэлгэрэнгүй мэдээллийг SAP тэмдэглэгээ 0015023 болон 0045619-с үзнэ үү.

10.7.12 Суулгалтын дараах алхмууд

10.7.12.1 SAP R/3-ийн лиценз түлхүүрийг хүснэ

Та өөрийн **SAP R/3** лиценз түлхүүрийг хүсэх хэрэгтэй. Суулгалтын үед суулгагдсан түр зуурын лиценз нь зөвхөн дөрвөн долоо хоног хүчинтэй байдаг болохоор ингэх хэрэгтэй юм. Эхлээд тоног төхөөрөмжийн түлхүүрийг авах хэрэгтэй. `idsadm` хэрэглэгчээр нэвтэрч `saplicense` тушаалыг дуудна:

```
# /sapmnt/IDS/exe/saplicense -get
```

`saplicense` тушаалыг параметрүүдгүй дуудах нь тохируулгуудын жагсаалтыг үзүүлдэг. Лицензийн түлхүүрийг авсныхаа дараа үүнийг дараах тушаалыг ашиглан суулгаж болно:

```
# /sapmnt/IDS/exe/saplicense -install
```

Тэгээд та дараах утгуудыг оруулах шаардлагатай болно:

```
SAP SYSTEM ID   = SID, 3 chars
CUSTOMER KEY    = hardware key, 11 chars
INSTALLATION NO = installation, 10 digits
EXPIRATION DATE = yyyymmdd, usually "99991231"
LICENSE KEY     = license key, 24 chars
```

10.7.12.2 Хэрэглэгчдийг үүсгэх

Клиент 000 дотор хэрэглэгч үүсгэнэ (зарим ажлуудын хувьд клиент 000 дотор хийхийг шаарддаг, гэхдээ `sap*` болон `ddic` хэрэглэгчдээс өөр хэрэглэгчээр). Хэрэглэгчийн нэрийн хувьд бид `wartung` (эсвэл Англиар `service`) гэж ихэвчлэн сонгодог. Шаардлагатай хувийн тохиргоонууд нь `sap_new` болон `sap_all` юм. Аюулгүй байдлыг нэмэлтээр хангаж бүх клиентүүд доторх анхдагч хэрэглэгчдийн нууц үгсийг өөрчлөх хэрэгтэй (эдгээр хэрэглэгчдэд `sap*` болон `ddic` орно).

10.7.12.3 Тээвэрлэлтийн систем, хувийн тохиргоо, үйлдлийн горимууд гэх мэтийг тохируулах

`ddic` болон `sap*` хэрэглэгчээс өөр клиент 000 дотор доор дурдсаныг хамгийн багадаа хийх хэрэгтэй:

Ажил	Шилжүүлгэ
Тээвэрлэлтийн системийг тохируулна, өөрөөр хэлбэл *Тусдаа ажиллах Тээвэрлэлтийн Домэйн* маягаар	STMS
Системийн хувьд хувийн тохиргоог үүсгэнэ / засварлана	RZ10
Үйлдлийн горимууд болон тохиолдлуудыг арчилна	RZ04

Эдгээр болон бусад бүх суулгалтын дараах алхмууд нь **SAP**-г суулгах зааврууд дэлгэрэнгүй тайлбарлагдсан байгаа.

10.7.12.4 `init`*`sid`*`.sap` (`initIDS.sap`) файлыг засварлана

`/oracle/IDS/dbs/initIDS.sap` файл **SAP**-ийн нөөц хувийн тохиргоог агуулдаг. Энд ашиглагдах соронзон хальсны хэмжээ, шахалтын төрөл гэх зэргийг тодорхойлох хэрэгтэй. `sapdba` / `brbackup` тушаалаар үүнийг ажиллуулахын тулд бид дараах утгуудыг өөрчилсөн:

```
compress = hardware
archive_function = copy_delete_save
cpio_flags = "-ov --format=newc --block-size=128 --quiet"
cpio_in_flags = "-iuv --block-size=128 --quiet"
tape_size = 38000M
tape_address = /dev/nsa0
tape_address_rew = /dev/sa0
```

Тайлбарууд:

`compress`: Бидний ашиглах соронзон хальс бол HP DLT1 бөгөөд энэ нь тоног төхөөрөмжийн шахалтыг хийдэг.

`archive_function`: Энэ нь Oracle-ийн архив бүртгэлүүдийг хадгалах анхдагч үйлдлийг тодорхойлдог: шинэ бүртгэлийн файлууд нь соронзон хальсанд хадгалагдаж аль хэдийн хадгалагдсан бүртгэлийн файлууд нь дахин хадгалагдаж дараа нь устгагддаг. Хэрэв танд мэдээллийн баазыг сэргээх хэрэг байгаа бөгөөд аль нэг архивын соронзон хальс муудсан бол энэ нь их олон асуудлаас сэргийлэх юм.

`cpio_flags`: Анхдагч нь блокийн хэмжээг 5120 байт болгож тохируулдаг `-B` тохируулгыг ашиглах явдал юм. DLT соронзон хальснуудын хувьд HP нь хамгийн багаар бодоход 32 K блокийн хэмжээтэй байхыг зөвлөдөг, тийм болохоор бид 64 K-д зориулж `--block-size=128` тохируулгыг ашигласан. Бидэнд 65535-с их inode дугаарууд байгаа болохоор `--format=newc` тохируулга хэрэгтэй. Сүүлийн тохируулга `--quiet` нь хэрэгтэй бөгөөд тэгэхгүй бол `cpio` тушаал хадгалсан блокуудын тоог гаргасны дараа `brbackup` тушаал гомдоллох болно.

`cpio_in_flags`: Соронзон хальснаас өгөгдлийг буцааж дуудахад тугнууд хэрэгтэй. Хэлбэршилт автоматаар танигддаг.

`tape_size`: Энэ нь соронзон хальсны түүхий хадгалалтын багтаамжийг ихэвчлэн өгдөг. Аюулгүй байдлын үүднээс (бид тоног төхөөрөмжийн шахалтыг ашиглаж байгаа) уг утга нь жинхэнэ утгаас хамаагүй бага байна.

`tape_address`: `cpio` тушаалд ашиглагдах дахин буцаагддаггүй төхөөрөмж байна.

`tape_address_rew`: `cpio` тушаалд ашиглагдах буцаагдаж болох төхөөрөмж байна.

10.7.12.5 Суулгалтын дараах тохиргооны асуудлууд

Суулгалтын дараа дараах **SAP** параметрүүдийг тааруулах хэрэгтэй (IDES 46B, 1 GB санах ойд зориулсан жишээнүүд):

Нэр	Утга
ztta/roll_extension	250000000
abap/heap_area_dia	300000000
abap/heap_area_nondia	400000000
em/initial_size_MB	256
em/blocksize_kB	1024
ipc/shm_psize_40	70000000

SAP Тэмдэглэгээ 0013026:

Нэр	Утга
ztta/dynpro_area	2500000

SAP Тэмдэглэгээ 0157246:

Нэр	Утга
rdisp/ROLL_MAXFS	16000
rdisp/PG_MAXFS	30000

> **Note:** Дээрх параметрүүдтэй 1 гигабайт санах ойтой систем дээр санах ойн иймэрхүү хэрэглээг олж харж болох юм:

```
Mem: 547M Active, 305M Inact, 109M Wired, 40M Cache, 112M Buf, 3492K Free
```

10.7.13 Суулгалтын үеийн асуудлууд

10.7.13.1 Асуудлыг засварласны дараа R3SETUP-г дахин эхлүүлнэ

R3SETUP тушаал алдаа гарвал зогсдог. Хэрэв та харгалзах бүртгэлийн файлуудыг үзэж алдааг зассан бол R3SETUP тушаалыг дахин эхлүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд R3SETUP-ийн гомдоллосон сүүлийн алхамд зориулж ихэвчлэн REPEAT-ийг тохируулга болгон сонгоно.

R3SETUP-г дахин эхлүүлэхийн тулд түүнийг ердөө л харгалзах R3S файлтай нь эхлүүлнэ, 4.6B-ийн хувьд:

```
# ./R3SETUP -f CENTRDB.R3S
```

эсвэл 4.6C-ийн хувьд

```
# ./R3SETUP -f CENTRAL.R3S
```

байх бөгөөд алдаа CENTRAL.R3S юм уу эсвэл DATABASE.R3S файлд гарснаас үл хамаарах юм.

> **Note:** Зарим алхмууд дээр R3SETUP тушаал нь мэдээллийн бааз болон **SAP** процессууд нь эхлээд ажиллаж байгаа гэж үздэг (тэдгээр нь аль хэдийн гүйцэтгэсэн алхмууд юм). Алдаанууд гарахад, жишээ нь мэдээллийн баазыг эхлүүлж болохгүй байвал алдаануудыг засварласны дараа R3SETUP-г дахин эхлүүлэхээсээ өмнө та мэдээллийн бааз болон **SAP**-ийг гараараа эхлүүлэх хэрэгтэй.
>
> **Oracle** сонсогч хэрэв (жишээ нь системийг шаардлагаар дахин ачаалснаас болоод) зогссон бол түүнийг бас (ora*sid* хэрэглэгчээр umask 0; lsnrctl start тушаалаар) дахин эхлүүлэхээ битгий мартаарай.

10.7.13.2 R3SETUP-ийн үе дэх OSUSERSIDADM_IND_ORA

Хэрэв R3SETUP энэ үе дээр гомдоллож байвал тэр үед R3SETUP-ийн ашиглагдсан загвар файлыг засварлах хэрэгтэй (CENTRDB.R3S (4.6B) эсвэл CENTRAL.R3S эсвэл DATABASE.R3S (4.6C)). [OSUSERSIDADM_IND_ORA]-г олох юм уу эсвэл зөвхөн STATUS=ERROR оруулгыг хайж дараах утгуудыг засварлах хэрэгтэй:

```
HOME=/home/sidadm (was empty)
STATUS=OK (had status ERROR)
```

Дараа нь та R3SETUP-г дахин эхлүүлж болно.

10.7.13.3 R3SETUP-ийн үе дэх OSUSERDBSID_IND_ORA

Магадгүй R3SETUP тушаал бас энэ үед гомдоллох байх. Энд байгаа алдаа нь OSUSERSIDADM_IND_ORA үе дэх алдаатай төстэй юм. Тэр үед R3SETUP-ийн ашиглагдсан загвар файлыг засварлах хэрэгтэй (CENTRDB.R3S (4.6B) эсвэл CENTRAL.R3S эсвэл DATABASE.R3S (4.6C)). [OSUSERDBSID_IND_ORA]-г олох юм уу эсвэл зөвхөн STATUS=ERROR оруулгыг хайж тэр хэсэг дэх дараах утгыг засварлах хэрэгтэй:

```
STATUS=OK
```

Дараа нь R3SETUP-г дахин эхлүүлнэ.

10.7.13.4 Oracle-ийн суулгалтын үе дэх "oraview.vrf FILE NOT FOUND"

Та суулгалтыг эхлүүлэхээсээ өмнө *Oracle On-Line Text Viewer* сонголтыг болиулаагүй байна. Энэ тохируулга нь Линукс дээр байдаггүй ч гэсэн суулгагдахаар тэмдэглэгдсэн байдаг. **Oracle** суулгалтын цэсэн дотор энэ бүтээгдэхүүнийг сонгосноо болиулаад суулгалтыг дахин эхлүүлэх хэрэгтэй.

10.7.13.5 R3SETUP, RFC эсвэл SAPgui Эхлэлийн үе дэх "TEXTENV_INVALID"

Хэрэв энэ алдаа гарсан бол зөв локал байхгүй байна. SAP тэмдэглэгээ 0171356 нь суулгахад шаардлагатай RPM-үүдийг жагсаасан байдаг (өөрөөр хэлбэл RedHat 6.1-т зориулсан saplocales-1.0-3, saposcheck-1.0-1). Та R3SETUP тушаал гомдоллох бүрт бүх хамааралтай алдаануудыг хаяж харгалзах STATUS тохируулгыг ERROR гэдгээс OK болгон (CENTRDB.R3S файлд) тохируулж R3SETUP-г дахин эхлүүлсэн бол **SAP** систем нь зөв тохируулагдахгүй бөгөөд хэдий системийг эхлүүлж болох ч гэсэн та дараа нь системд **SAPgui** програмаар холбогдож чадахгүй болно. Линуксийн хуучин **SAPgui**-аар холбогдохыг оролдоход дараах мэдэгдлүүдийг өгсөн:

```
Sat May 5 14:23:14 2001
*** ERROR => no valid userarea given [trgmsgo. 0401]
Sat May 5 14:23:22 2001
*** ERROR => ERROR NR 24 occured [trgmsgi. 0410]
*** ERROR => Error when generating text environment. [trgmsgi. 0435]
*** ERROR => function failed [trgmsgi. 0447]
*** ERROR => no socket operation allowed [trxio.c 3363]
Speicherzugriffsfehler
```

Энэ ажиллагаа нь **SAP R/3**-ийн локалыг зөв зааж өгч чадахгүй байдал болон бас өөрийгөө зөв тохируулж чадахгүй (зарим мэдээллийн баазын хүснэгтүүдэд оруулгууд байхгүй) байдлаас болдог. **SAP** уруу холбогдож чаддаг байхын тулд DEFAULT.PFL файлд дараах оруулгуудыг нэмнэ (Тэмдэглэгээ 0043288-г үзнэ үү):

```
abap/set_etct_env_at_new_mode = 0
install/collate/active = 0
rscp/TCP0B = TCP0B
```

SAP системийг дахин эхлүүлнэ. Улстай холбоотой хэлний тохиргоонууд хүссэнээр ажиллахгүй байсан ч гэсэн одоо та систем уруу холбогдож чадна. Улсын тохиргоонуудыг зөв болгосны (зөв локалыг зааж өгсний) дараа эдгээр оруулгуудыг DEFAULT.PFL файлаас арилгаж **SAP** системийг дахин эхлүүлж болно.

10.7.13.6 ORA-00001

Энэ алдаа нь FreeBSD дээрх **Oracle 8.1.7** дээр зөвхөн гардаг. Үүний шалтгаан нь **Oracle** мэдээллийн бааз өөрийгээ зөв эхлүүлж чадахгүй, систем дээр семафорууд болон хуваалцсан санах ойг үлдээн сүйрдэг явдал юм. Мэдээллийн баазыг эхлүүлэх дараагийн оролдлого тэгээд ORA-00001 алдааг буцаадаг.

`ipcs -a` тушаалаар тэдгээрийг олж `ipcrm` тушаалаар устгах хэрэгтэй.

10.7.13.7 ORA-00445 (Арын процесс PMON эхлээгүй)

Энэ алдаа нь **Oracle 8.1.7** дээр гардаг. Энэ алдаа нь мэдээллийн бааз `prdadm` хэрэглэгчээр ердийн `startsap` скриптээр (жишээ нь `startsap_majestix_00`) эхлүүлэгдсэн бол гардаг.

Боломжит тойрон гарах зам нь `oraprd` хэрэглэгчээр `svrmgrl` тушаалын тусламжтай мэдээллийн баазыг эхлүүлэх явдал юм:

```
% svrmgrl
SVRMGR> connect internal;
SVRMGR> startup;
SVRMGR> exit
```

10.7.13.8 ORA-12546 (Сонсогчийг зөв зөвшөөрлүүдтэй эхлүүлэх)

`oraids` хэрэглэгчээр **Oracle** сонсогчийг дараах тушаалаар эхлүүлнэ:

```
# umask 0; lsnrctl start
```

Ингэхгүй бол сокетууд нь зөв зөвшөөрлүүдгүйн улмаас та ORA-12546 алдаа харж болох юм. SAP тэмдэглэгээ 0072984-г үзнэ үү.

10.7.13.9 ORA-27102 (Out of Memory буюу санах ой хүрэлцэхгүй)

`MAXDSIZ` болон `DFLDSIZ` тохируулгуудын хувьд 1 GB-с (1024x1024x1024) их хэмжээтэй утгуудыг ашиглахаар оролдох үед энэ алдаа гарсан. Мөн "`Linux Error 12: Cannot allocate memory`" буюу санах ойг хуваарилж чадахгүй байна гэсэн алдааг бид бас авсан.

10.7.13.10 R3SETUP-ийн үе дэх [DIPGNTAB_IND_IND]

Ерөнхийдөө SAP тэмдэглэгээ 0130581-г үзнэ үү (`R3SETUP` алхам `DIPGNTAB` төгссөн). IDES-тэй холбоотой суулгалтын үед ямар нэг шалтгаанаас болоод суулгах процесс зөв **SAP** системийн нэр "IDS"-г ашиглалгүй хоосон мөр `""`-г ашигладаг. Замууд нь динамикаар *`SID`*-г (энэ тохиолдолд IDS) ашиглан үүсгэгддэг учраас энэ нь сангуудад хандах үед зарим нэг жижиг асуудлуудад хүргэдэг. Доор дурдсан уруу хандахын оронд:

```
/usr/sap/IDS/SYS/...
/usr/sap/IDS/DVMGS00
```

дараах замуудыг ашигласан:

```
/usr/sap//SYS/...
```

```
/usr/sap/D00
```

Суулгалтыг үргэлжлүүлэхийн тулд бид холбоос болон нэмэлт сан үүсгэсэн:

```
# pwd
/compat/linux/usr/sap
# ls -l
total 4
drwxr-xr-x 3  idsadm sapsys 512 May 5 11:20 D00
drwxr-x--x 5  idsadm sapsys 512 May 5 11:35 IDS
lrwxr-xr-x 1  root   sapsys 7 May 5 11:35 SYS -> IDS/SYS
drwxrwxr-x 2  idsadm sapsys 512 May 5 13:00 tmp
drwxrwxr-x 11 idsadm sapsys 512 May 4 14:20 trans
```

SAP тэмдэглэгээнүүд (0029227 болон 0008401) үүнийг тайлбарладгийг бид бас олсон юм. Бид эдгээр асуудлуудын алийг ч **SAP 4.6C** суулгалтаас олж хараагүй.

10.7.13.11 R3SETUP-ийн үе дэх [RFCRSWBOINI_IND_IND]

SAP 4.6C-г суулгаж байхад энэ алдаа нь суулгалтын эхэн үед гарсан өөр алдаанаас болж гарсан алдаа байсан. Энэ тохиолдолд та харгалзах бүртгэлийн файлуудыг үзэж жинхэнэ асуудлыг засварлах хэрэгтэй.

Бүртгэлийн файлуудыг үзсэний дараа хэрэв энэ алдаа нь харин зөв бол (SAP тэмдэглэгээнүүдийг шалгана уу) зөрчсөн алхмын `STATUS` тохируулгыг `ERROR` гэдгээс `OK` уруу (файл `CENTRDB.R3S`) болгож тохируулан `R3SETUP`-г дахин эхлүүлж болно. Суулгалтын дараа та шилжүүлгэ SE38-аас тайлан `RSWBOINS`-г ажиллуулах хэрэгтэй. `RFCRSWBOINI` болон `RFCRADDBDIF` үеүүдийн тухай нэмэлт мэдээллийг SAP тэмдэглэгээ 0162266-с үзнэ үү.

10.7.13.12 R3SETUP-ийн үе дэх [RFCRADDBDIF_IND_IND]

Энд ижил хязгаарлалтууд ашиглагдана: бүртгэлийн файлуудыг үзэж энэ алдаа нь урьдны өөр асуудлуудаас болсон эсэхийг шалгана.

Хэрэв та SAP тэмдэглэгээ 0162266 хамаарч байгааг баталбал зөрчсөн алхмын `STATUS` тохируулгыг `ERROR` гэдгээс `OK` уруу (файл `CENTRDB.R3S`) болгож тохируулан `R3SETUP`-г дахин эхлүүлэх хэрэгтэй. Суулгалтын дараа та шилжүүлгэ SE38-аас тайлан `RADDBDIF`-г ажиллуулах хэрэгтэй.

10.7.13.13 sigaction sig31: File size limit exceeded буюу файлын хэмжээний хязгаар илүүдсэн

Энэ алдаа нь **SAP**-ийн процессууд *disp+work*-г эхлүүлэх үед гардаг. Хэрэв **SAP**-г `startsap` скриптээр эхлүүлэхэд дэд процессууд нь дараа нь эхлүүлэгдэх бөгөөд эдгээр нь бусад бүх **SAP** процессуудыг эхлүүлэх бохир ажлыг хийж салдаг. Үүний үр дүнд скрипт нь өөрөө ямар нэг зүйл буруу болохыг анзаардаггүй.

SAP-ийн процессууд зөв эхэлсэн эсэхийг шалгахын тулд `ps ax | grep` *`SID`* тушаалаар процессийн төлөвийг үзэх хэрэгтэй. Энэ нь танд **Oracle** болон **SAP**-ийн бүх процессуудын жагсаалтыг харуулдаг. Хэрэв зарим процессууд байхгүй юм уу эсвэл та **SAP** систем уруу холбогдож чадахгүй байвал `/usr/sap/`*`SID`*`/DVEBMGS`*`nr`*`/work/` санд байх харгалзах бүртгэлийн файлуудыг үзэх хэрэгтэй. Үзэх файлууд нь `dev_ms` болон `dev_disp` юм.

Oracle болон **SAP**-ийн ашигласан хуваалцсан санах ойн хэмжээ цөмийн тохиргооны файлд тааруулснаас илүү гарвал энд дохио 31 гарах бөгөөд илүү том утгыг ашиглаж энэ асуудлыг шийдэж болно:

```
# larger value for 46C production systems:
options SHMMAXPGS=393216
# smaller value sufficient for 46B:
#options SHMMAXPGS=262144
```

10.7.13.14 `saposcol` тушаалын эхлэл амжилтгүй болсон

`saposcol` программ (хувилбар 4.6D) зарим асуудлууд байдаг. **SAP** систем нь системийн ажиллагааны тухай өгөгдлийг цуглуулахын тулд `saposcol`-г ашигладаг. Энэ програм нь **SAP** системийг ашиглахад хэрэггүй болохоор энэ асуудлыг жижиг гэж тооцож болох юм. Хуучин хувилбарууд (4.6B) нь ажилладаг боловч бүх өгөгдлийг цуглуулдаггүй (олон дуудлагууд нь 0-г буцаах болно, жишээ нь CPU-ийн хэрэглээний хувьд).

10.8 Нэмэлт сэдвүүд

Хэрэв та Линуксийн хоёртын нийлэмж хэрхэн ажилладгийг мэдэхийг хүсэж байгаа бол энэ хэсэг нь таны уншихыг хүсэж байгаа хэсэг юм. Доор бичигдсэн зүйлийн ихэнх нь Тэрри Лэмбэрт <`tlambert@primenet.com`>-ийн FreeBSD chat захидлын жагсаалт (http://lists.FreeBSD.org/mailman/listinfo/freebsd-chat) руу бичсэн цахим захидал (Message ID: <`199906020108.SAA07001@usr09.primenet.com`>) дээр тулгуурласан байгаа.

10.8.1 Хэрхэн ажилладаг вэ?

FreeBSD нь “execution class loader” буюу ажиллуулах ангилал дуудагч гэгддэг хийсвэрлэлттэй байдаг. Энэ нь execve(2) системийн дуудлага уруу хийгдэх шаантаг юм.

Юу болдог вэ гэхээр FreeBSD нь ямар нэгэн бүрхүүлийн тайлбарлагчид эсвэл бүрхүүлийн скриптүүдийг ажиллуулахын тулд `#!` дуудагч уруу ордог нэг дуудагчийн оронд дуудагчдын жагсаалттай байдаг.

Уламжлалаар бол UNIX тавцангийн дуудагч нь хоёртын файлыг системд мэдэгдэж байгаа эсэхийг мэдэхийн тулд шидэт тоог (ерөнхийдөө файлын эхний 4 эсвэл 8 байт) шалгадаг бөгөөд хэрэв мэдэгдэж байвал хоёртын дуудагчийг ажиллуулдаг ганц дуудагч юм.

Хэрэв энэ нь системд зориулагдсан хоёртын төрөл биш бол execve(2) дуудлага амжилгүй болон буцаж бүрхүүл үүнийг бүрхүүлийн тушаалууд маягаар ажиллуулж эхлэхийг оролддог.

“Тухайн үеийн бүрхүүл ямар байгаа” түүнийг анхдагч гэж таамагладаг.

Дараа нь эхний хоёр тэмдэгтүүдийг шалгах засварыг (hack) sh(1)-д зориулж хийсэн бөгөөд хэрэв тэдгээр нь `:\n` бол энэ нь csh(1) бүрхүүлийг ажиллуулдаг (энэ засварыг SCO анхлан хийсэн гэж бид итгэдэг).

